



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар #208

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх  
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.
2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Төв эмнэлгийн магадлан итгэмжлэлийг Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлсэн хугацаагаар түр түдгэлзүүлсүгэйб
3. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн аравдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Сүнчин)-т даалгасугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



141223971

Эрүүл мэндийн сайдын 2023  
оны 06 сарын 12 - ны өдрийн  
4/208 дугаар тушаалын хавсралт



**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
БАЙГУУЛЛАГЫН НЭРС**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэ н хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Дотны туслагч өрхийн эрүүл мэндийн төв	159/2023	1 жил	2023.06.16	2024.06.16
2.	ДУБ ХХК-ийн Мед траума хоспитал эмнэлэг	160/2023	3 жил	2023.06.24	2026.06.24
3.	Чимэжүд ХХК-ийн Чимэжүд эмнэлэг	161/2023	2 жил	2023.06.13	2025.06.13